



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Одонгийн ЦОГТГЭРЭЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 28-34-14, Факс: 32-30-34  
E-mail: tsogtgerelo@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2023.04.05 № ЧУХ-03/1880

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд "Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын байнгын болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О. ЦОГТГЭРЭЛ

Д. ГАНБАТ

2023000097



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Одонгийн ЦОГТГЭРЭЛ

14201 Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,  
Утас: 26-34-14, Факс: 32-30-34  
E-mail: tsogtgerelo@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2023. 04. 04 № ЧИД-03/2866

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Тов тогтоолгох тухай Г

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төслийн бүрдүүлбэрийг хавсаргав.

Хавсралт .49 хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

О. ЦОГТГЭРЭЛ



2023000095



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
О.ЦОГТГЭРЭЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

додл. 04. 04 № ХГТ/766  
танай -ны № -т

Санал хүргүүлэх тухай

Танаас 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн УИХ-03/2812 дугаар албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын санаачлан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж, холбогдох саналаа хууль санаачлагчид хүргүүлсэн.

Улсын Их Хурлын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулах агуулга бүхий Таны санаачлан боловсруулсан хуулийн төсөл нь зарчмын хувьд дээрх хуулийн төсөлтэй адил байх бөгөөд үүнтэй холбогдуулан Засгийн газраас байр сууриа нэгэнт илэрхийлсэн тул хавсралтаар Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны холбогдох тэмдэглэлийг хуулбарлан хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт хуудастай

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

000235002676

**МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭС**

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэлд:

"**Ү.ХЭЛЭЛЦЭН** нь:

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын санаачлан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн тесел

**ШИЙДВЭРЛЭСЭН** нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын санаачлан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн теслийг хэлэлцээд дараах саналыг хууль санаачлагчдад уламжлахаар тогтов:

1. Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигч нь нэгэн зэрэг сонгуулийн тойргоос нэр дэвших нь зарчмын хувьд боломжгүй тул хуулийн теслийн 74.2.8-д "Энэ хуулийн 74.2.7-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигч нь энэ хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон бол жагсаалтаас тухайн нэр дэвшигчийн дараагийн нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно" гэснийг залруулж, сонгуулийн тойрог болон нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаас зэрэг нэр дэвшихийг хориглох зорилгоор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (цаашид "хууль" гэх)-ийн 29 дүгээр зүйлд дараах хэсгийг нэмж тусгах:

"29.9. Тойрот болон жагсаалтад зэрэг нэр дэвшихийг хориглоно."

2. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт оруулах нэмэлттэй холбогдуулан хуулийн теслийн 1 дүгээр зүйлийн 36, 37, 38 дахь хэсэг буюу хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.2, 74.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"74.1. Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 4.3.1-д заасан сонгуулийн тойрот нэр дэвшигчийн санал хураалтын дунг дараах байдлаар гаргана:

74.1.1. санал хураалтын дунг үндэслэн тухайн тойрот нэр дэвшсэн нийт нэр дэвшигчийг авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргана;

74.1.2. хамгийн олон санал авсан, тухайн тойрот ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.

74.2. Дараах шаардлагыг хангасан нам, эвсэлд энэ хуульд заасны дагуу суудал хуваарилна:

74.2.1. Энэ хуулийн 4.3.1-д заасан тойрот ногдох нийт мандатын 50 буюу түүнээс дээш хувьд нь нэр дэвшүүлсэн байх;

**74.2.2.намын тухайд намд өгсөн нийт саналын 3 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх;**

**74.2.3.хоёр нам бүхий эвслийн тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 5 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх;**

**74.2.4.гурав буюу түүнээс дээш нам бүхий эвслийн тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 7 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх.**

**74.3.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигчийн санал хураалтын дүнг дараах байдлаар гаргана:**

**74.3.1.санал хураалтын дүнг үндэслэн нам, эвсэл тус бүрээр авсан саналын тоо, хувиар дараалалд оруулан жагсаалт гаргана;**

**74.3.2.энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангаагүй нам, эвслийн авсан нийт саналын хувийг мөн хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвсэлд тэнцүү хэмжээгээр хуваан тус бүрийн авсан саналын хувь дээр нэмж тооцно;**

**74.3.3.энэ хуулийн 74.3.2-т заасны дагуу тооцож гаргасан хувиудын нийлбэрийг 38-д хувааж нэг суудалд ногдох саналын тоо, хувийг тооцож гаргана;**

**74.3.4.энэ хуулийн 74.3.2-т заасны дагуу тооцож гаргасан нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувийг энэ хуулийн 74.3.3-т заасны дагуу тооцож гаргасан нэг суудалд ногдох саналын хувьд хувааж Улсын Их Хурлын гишүүний 38 суудлыг их үлдэгдлийн зарчмаар хувь тэнцүүлэн хуваарилна;**

**Тайлбар: Их үлдэгдлийн зарчмаар хувь тэнцүүлэн хуваарилах гэж энэ хуулийн 74.3.4-т заасны дагуу нэг суудалд ногдох саналын хувьд хуваахдаа бутархай нарийвчлалтай гаргаж, эхний ээлжид бүхэл хэсэгт нь тэнцэх суудлыг хуваарилах, хэрэв хуваарилагдаагүй суудал үлдвэл хамгийн их үлдэгдэл буюу хамгийн их бутархай хувьтайгаас нь эхлэн нэг нэгээр суудлыг нам, эвсэлд нэмж хуваарилах зарчмаар бүх суудлыг хуваарилж дуусахыг ойлгоно.**

**74.3.5.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуульд заасны дагуу нам, эвслээс ирүүлсэн нэр дэвшигчдийн жагсаалтыг үндэслэн энэ хуулийн 74.3.4-т заасны дагуу хуваарилсан суудлын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.**

**74.4.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 74.1, 74.3-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэр гаргаж, Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх олгож, нийтэд мэдээлнэ.”**

**3.Хүйсийн төлөөллийн тэнцвэртэй байдлыг боломжит түвшинд хангах хүрээнд хуулийн теслийн 30.5-д “Нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшигчдээс 3:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэн нэр дэвшигчдээс “1:1 хүйсийн харьцаатай” гэж өөрчлөх.**

**4.Сонгуулийн зардлыг бууруулах хүрээнд дараах зохицуулалтыг хуульд тусгах нь зүйтэй:**

**“4.1.хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “нэг хэсэгт дөрвөөс илүүгүй тээврийн хэрэгсэл” гэснийг “хоёроос илүүгүй” гэж өөрчлөх;**

**4.2.хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.1 дэх заалтын "гурван хэвлэлийн хуудас сонин", 41.1.2 дахь заалтын "гурван хэвлэлийн хуудас сэтгүүл" гэснийг тус тус "хоёр" болгож өөрчлөх;**

**4.3.хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн "Сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц ашиглаж болох ба зурагт самбар, дэлгэц нь нэг хэсэгт 10-аас илүүгүй" гэснийг "аймгийн төв болон дүүргийн нэг хэсэгт 5, бусад хэсэгт 3-аас илүүгүй" гэж өөрчлөх;**

**4.4.сонгуульд нэр дэвшигч нь нийслэлд 800 хүртэл, бусад газарт 400 хүртэл сонгогч тутамд нэг ухуулагчтай байхаар хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэгт өөрчлөлт оруулж, ухуулагчид олгох урамшууллын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоох асуудлыг нэмж тусгах;**

**4.5.нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дээд хэмжээ сонгуулийн тойрот нэр дэвшигчийн зардлын хэмжээний 50 хувиас хэтрэхгүй байх зохицуулалтыг хуулийн 50 дугаар зүйлд нэмж тусгах;**

**4.6.цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаанд зарцуулах зардал нь нам, эсвэл, нэр дэвшигчийн сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээний 15 хувиас хэтрэхгүй байх зохицуулалтыг хуулийн 47 дугаар зүйлд нэмж тусгах."**

**5.Сонгуулийн үйл ажиллагаанд зориулсан мөнгөн хандивын хэмжээг иргэнд 10 сая, хуулийн этгээдэд 30 сая төгрөг болгон нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгах.**

**6.Сонгуулийн сурталчилгааны явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд хуулийн 46 дугаар зүйлд нам, эсвэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байх, мөн радио, телевизийн хүүхдэд зориулсан зохицуулалтыг оруулах.**

**7.Хуульд заасан журмын дагуу сонгуулийн зардлын тайлангаа гаргаж өгөөгүй нам, эсвэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд оролцохыг бүртгэхээс татгалзах зохицуулалтыг нэмж тусгах.**

**8.Гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагаанд улсын төсвөөс багагүй хөрөнгө зарцуулдаг боловч санал авч буй дипломат төлөөлөгчийн газраас өөр хотод байгаа Монгол Улсын иргэн Сонгуулийн еренхий хорооноос тогтоосон хоёр хоногт багтаан санал авах байранд очиход хүндрэлтэйгээс гадна өндөр зардалтайгаас шалтгаалж санал авах өдөр ирэхээр бүртгүүлэх иргэдийн тоо практикт цөөн байдаг. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны элжит сонгуулийн үеэр гадаадын 30 улсын 44 дипломат төлөөлөгчийн газарт санал авахад нийт 7394 иргэн нэрийн жагсаалтад бүртгүүлснээс 5568 иргэн санал авах байранд ирж санал өгсөн байдаг.**

**Иймд гадаад улсад суугаа Монгол Улсын иргэний сонгох эрхийг баталгаатай эдлүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор иргэн гадаад улсад санал өгөхөд тулгардаг хүндрэл, бэрхшээлийг бууруулах чиглэлээр дэвшилтэт зохицуулалт бий болгох нь зүйтэй. Тухайлбал, хуулийн төслийн**

63 дугаар зүйлд тусгасан урьдчилан санал авах ажиллагааг гадаадад байгаа иргэдээс санал авахад ашиглах боломжтой байхаар тусгаж болно.

9.Хуулийн төслийн 75.3-т "...хуулийн 35.3, 38.2, 48.1, 48.5.1, 48.5.2, 56.2-т заасныг зөрчсөн болох нь энэ хуульд заасны дагуу сонгуулийн дүн гаргасны дараа буюу Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь хэрэгжиж эхлэхээс өмнө тогтоогдсон бол Сонгуулийн өрөнхий хороо тухайн нэр дэвшигчийг сонгогдсонд тооцсон тухай шийдвэрээ хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ" гэж заасан нь тухайн санал хураалтын хүчинтэй байдал, санал хураалтын дүнг тооцож гаргах зэрэгт тодорхойгүй үр дагаврыг үүсгэх тул уг зохицуулалтыг төслөөс хасах.

10.Хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулах хуулийн төслүүдийг тодорхой болгох шаардлагатай. Тухайлбал, төслийн 81.8-д тусгасан захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу зохицуулж байх тул шаардлагатай гэж үзвэл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай болон Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй.

Түүнчлэн Төрийн албаны тухай хуульд заасан зэрэг, дэвийг олгохдоо "сонгуулийн байгууллага"-д ажилласан байдлыг харгалзаж, тодорхой байгууллагын нэрийг тухайлан заах нь эрх тэгш байх, шударга байх хуулийн үндсэн зарчимтай нийцэхгүй тул төслийг дагалдуулан боловсруулсан Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь хасах шаардлагатай.

Мөн хуулиас гадуур нам, эвсэл, нэр дэвшигчид санхүүгийн дэмжлэг үзүүлсэн аливаа үйлдлийг гэмт хэрэгт тооцож, хүлээлгэх хариуцлагыг чангатгах чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй байна.

11.Хуулийн төсөлтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, эсхүл тандан судалгааны тайлан, хуулийн төслийн үр нэлөөний үнэлгээ, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, Төсвийн тухай хуульд заасан төсөвт үзүүлэх нэлөөллийн тооцоолол, судалгааг ирүүлээгүй байгааг анхаарч, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төсөл боловсруулах шаардлагыг бүрэн хангах нь зүйтэй." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.**

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

**О.ЦОГТГЭРЭЛ**

**УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах дараах үндэслэл байна. Үүнд:

**1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01 тоот тогтоол гарснаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог сонгох асуудал нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарч байгааг эцэслэн шийдвэрлэсэн.

**1.2.Практик үндэслэл**

Өнгөрсөн найман удаагийн Улсын Их Хурлын сонгуулийн дийлэнх олонхыг дан мажоритар системээр явуулсан. 2000 оны ээлжит сонгуулиар нийт сонгогчдын 51.5 хувийн саналыг авсан МАН Улсын Их Хурлын 76 суудлын 95 хувь буюу 72 суудлыг авсан бол 24.1 буюу нийт сонгогчдын дөрөвний нэгийн саналыг авсан Ардчилсан нам нэг суудал авч байжээ.

2016 онд нийт сонгогчдын 46.5 хувийн саналыг авсан МАН нь УИХ-д 65 суудал буюу нийт суудлын 85.5 хувийг, харин 34.2 хувийн санал авсан Ардчилсан нам 9 буюу нийт суудлын 12 хувийг тус тус авч байв.

Энэ удаагийн парламентыг бүрдүүлсэн 2020 оны Улсын Их хурлын ээлжит сонгуульд сонгогчдын 45 хувийн санал авсан МАН нийт суудлын 82 хувийг авсан бол нийт сонгогчдын 24 хувь буюу дервен сонгогч тутмын нэгийн саналыг авсан АН 11 суудал буюу нийт суудлын 14 хувийг авчээ.

Энэ мэтээр сонгуулийн үр дүн савалж, иргэд сонгогчдын санал гээгддэг муу жишиг мажоритор тогтолцоонд ихээр тохиолдож байна. Нийт сонгогчдын 50-аас доош хувийн санал авсан улс төрийн хүчин хууль тогтоох байгууллагад үнэмлэхүй суудал авч, засгийн бүх эрхийг авч байгаа нь иргэд сонгогчдын хүсэл зориг, шударга ёсны зарчимд нийцэхгүй байна.

Сонгуулийн тогтолцооны энэ гажуудлыг засахын тулд сонгуулийн холимог тогтолцоог хуульчилж, төрийн эрх мэдлийг ард түмэн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

Одоогийн мөрдөгдөж буй Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар аль нэг хүйсийн доод хэмжээ 20 хувьтай байгаа боловч сонгуулийн үр дүнгээр 20 хүрэхгүй

гишүүд сонгогддог практик бий. Ийм учраас хүйсийн квот дээр үр дүнтэй уялдах схемийг бүрдүүлэх шаардлага байна.

Мөн сонгуулийг шударгаар явуулах нөхцлийг бүрдүүлэх нь сонгуулийн тогтолцоог зөв сонгохоос дутуугүй ач холбогдолтой. Иймд энэхүү төслеөр сонгуулийг шударгаар зохион байгуулахтай холбоотой зохицуулалтыг дараах байдлаар тусгалаа.

### **Хоёр. Хуулийн төслийн зорилго, өрөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Төслеөр дараах нэмэлт өөрчлөлтийг оруулахаар тусгав. Үүнд:

- Сонгуулийн тогтолцоог холимог байхаар хуульчилж, тойргоос 48, жагсаалтаар 28 хүн сонгохоор зааж өгөв.
- Жагсаалт хуваарилахад улс нэг гэдэг зарчим барьсан.
- 48 мандатыг тойрог хуваах зарчмаар хуульд тусгаж өгсөн, өмнөх 12.2 дугаар зүйлийг энэ зарчимд нийцүүлж, өөрчлөн найруулав. Тойротг хамгийн олон санал авсан нэр дэвшигч явах ба нийт сонгогчийн 28 хувиас доош санал авсан тохиолдолд дахин санал хураалт явагдана.
- Нэр дэвшүүлэх зарчим хэвээр байхаар оруулсан.
- Тойротг болон жагсаалтад зэрэг нэр дэвшихийг хориглоно.
- Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчдийн 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.
- Нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэн нэр дэвшүүлнэ.
- Жагсаалт нээлттэй байна.
- Жагсаалтаар нэр дэвшсэн нам, эвслийн сонгуулийн дүн гаргах, суудал хуваарилах зарчмыг нам эвсэл 3 хувь байхаар оруулав. Мөн тойротг суудал авсан байх шалгуурыг оруулна.
- Тойргийн хорооны дарга, бүрэлдэхүүнийг гэрчилгээтэй төрийн захиргааны ба үйлчилгээний албан тушаалтан байхаар оруулсан.
- Сонгуульд санал өгсөн иргэн бэхэн тэмдэглэгээ заавал хийлгэнэ.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Эрүүгийн хууль, Төрийн Албаны тухай хууль, Төсвийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулна.

## ТАНИЛЦУУЛГА

### УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01 тоот тогтоол гарснаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог сонгох асуудал нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарч байгааг эцэслэн шийдвэрлэсэн.

Өнгөрсөн найман удаагийн Улсын Их Хурлын сонгуулийн дийлэнх олонхыг дан мажоритар системээр явуулсан. 2000 оны ээлжит сонгуулиар нийт сонгогчдын 51.5 хувийн саналыг авсан МАН Улсын Их Хурлын 76 суудлын 95 хувь буюу 72 суудлыг авсан бол 24.1 буюу нийт сонгогчдын дөрөвний нэгийн саналыг авсан Ардчилсан нам нэг суудал авч байжээ.

2016 онд нийт сонгогчдын 46.5 хувийн саналыг авсан МАН нь УИХ-д 65 суудал буюу нийт суудлын 85.5 хувийг, харин 34.2 хувийн санал авсан Ардчилсан нам 9 буюу нийт суудлын 12 хувийг тус тус авч байв.

Энэ удаагийн парламентыг бүрдүүлсэн 2020 оны Улсын Их хурлын ээлжит сонгуульд сонгогчдын 45 хувийн санал авсан МАН нийт суудлын 82 хувийг авсан бол нийт сонгогчдын 24 хувь буюу дөрвөн сонгогч тутмын нэгийн саналыг авсан АН 11 суудал буюу нийт суудлын 14 хувийг авчээ.

Энэ мэтээр сонгуулийн үр дүн савалж, иргэд сонгогчдын санал гээгддэг муу жишиг мажоритор тогтолцоонд ихээр тохиолдож байна. Нийт сонгогчдын 50-аас доош хувийн санал авсан улс төрийн хүчин хууль тогтоох байгууллагад үнэмлэхүй суудал авч, засгийн бүх эрхийг авч байгаа нь иргэд сонгогчдын хүсэл зориг, шударга ёсны зарчимд нийцэхгүй байна.

Сонгуулийн тогтолцооны энэ гажуудлыг засахын тулд сонгуулийн холимог тогтолцоог хуульчилж, төрийн эрх мэдлийг ард түмэн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

Одоогийн мөрдөгдж буй Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар аль нэг хүйсийн доод хэмжээ 20 хувьтай байгаа боловч сонгуулийн үр дүнгээр 20 хүрэхгүй гишүүд сонгогддог практик бий. Ийм учраас хүйсийн квот дээр үр дунтэй уялдах схемийг бүрдүүлэх шаардлага байна.

Мен сонгуулийг шударгаар явуулах нөхцлийг бүрдүүлэх нь сонгуулийн тогтолцоог зөв сонгохоос дутуугүй ач холбогдолтой. Иймд энэхүү төслөөр сонгуулийг шударгаар зохион байгуулахтай холбоотой зохицуулалтыг дараах байдлаар тусгалаа. Үүнд:

- Сонгуулийн тогтолцоог холимог байхаар хуульчилж, тойргоос 48, жагсаалтаар 28 хүн сонгохоор зааж өгөв.
- Жагсаалт хуваарилахад улс нэг гэдэг зарчим барьсан.
- 48 мандатыг тойрог хуваах зарчмаар хуульд тусгаж өгсөн, өмнөх 12.2 дугаар зүйлийг энэ зарчимд нийцүүлж, өөрчлөн найруулав. Тойрогот хамгийн олон санал авсан нэр дэвшигч явах ба нийт сонгогчийн 28 хувиас доош санал авсан тохиолдолд дахин санал хураалт явагдана.
- Нэр дэвшүүлэх зарчим хэвээр байхаар оруулсан.

- Тойрот болон жагсаалтад зэрэг нэр дэвшихийг хориглоно.
- Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчдийн 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.
- Нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэн нэр дэвшүүлнэ.
- Жагсаалт нээлттэй байна.
- Жагсаалтаар нэр дэвшсэн нам, эвслийн сонгуулийн дүн гаргах, суудал хуваарилах зарчмыг нам эвсэл 3 хувь байхаар оруулав. Мөн тойрот суудал авсан байх шалгуурыг оруулна.
- Тойргийн хорооны дарга, бүрэлдэхүүнийг гэрчилгээтэй төрийн захиргааны ба үйлчилгээний албан тушаалтан байхаар оруулсан.
- Сонгуульд санал өгсөн иргэн бэхэн тэмдэглэгээ заавал хийлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дүгээр сарын ...-ны өдөр  
Улаанбаатар хот

Төрийн

ордон,

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

**1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд дараах агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:**

**1/ 4.3.1.** Монгол Улсын Их Хурлын **48** гишүүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос;

**4.3.2.** Монгол Улсын Их Хурлын **28** гишүүнийг энэ хуульд заасны дагуу сонгуульд оролцоо бүртгүүлсэн нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаас.

**2/ 5.6.** Гадаад улсад байгаа иргэн сонгуульд оролцоо цахимаар илэрхийлж, энэ хуульд заасан журмын дагуу бүртгүүлэх бөгөөд санал өгөхдөө өөрийн биеэр санал авах байранд очиж өгнө.

**3/ 7.4.4.** Шуурхай байх.

**4/ 7.6.** Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд сонгуулийг Сонгуулийн өрөнхий хороо удирдан зохион байгуулж, хариуцлагыг бүрэн хүлээнэ.

**7.7.** Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон холбогдох бусад төрийн байгууллагууд сонгууль зохион байгуулахад шаардлагатай мэдээллийг энэ хуульд заасан үндэслэл, журам, шаардлагын дагуу Сонгуулийн өрөнхий хороонд гарган өгч, сонгууль зохион байгуулахад туслалцаа үзүүлнэ.

7.8. Сонгуульд нэгээс илүү удаа санал өгсөн, эсхүл нэг удаа санал өгсөнөө мэдсээр байж дахин санал өгөхөөр оролдсон нь хууль заасан хариуцлага хүлээх үндэслэл болно.

7.9. Нийтийн албан тушаалтан нь сонгуульд ашиглах иргэний улсын бүртгэлийн мэдээлэл болон сонгогчийн нэрийн жагсаалтад хуурамч мэдээлэл оруулсан, сонгогчийн нэрийг нэгээс илүү хаягт давхардуулан бүртгэсэн, сонгогчийн шилжилт хөдөлгөөнийг хууль зөрчиж гүйцэтгэсэн, сонгуульд нэгээс илүү санал өгөх нөхцөл боломжоор хангасан, уг нөхцөлийг хангахад оролцсон нь Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болно.

7.10. Сонгогчийн нэрийн жагсаалтад Сонгуулийн ерөнхий хорооноос гадна сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигч болон ажиглагч хяналт тавина.

5/ 10.1.14.гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажиллагааг зохион байгуулахтай холбогдон гарах зардал;

6/ 11.2. Энэ хуулийн 4.3.1-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнийг сонгох сонгуулийн нутаг дэвсгэр нь тойрогт хуваагдана. Тойрог хуваах зарчмыг энэ хуулиар тогтооно.

7/ 11.4. Улсын Их Хурлын гишүүнийг энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар сонгох сонгуульд Монгол Улсын нутаг дэвсгэр сонгуулийн нэг тойрог байна.

8/ 12.2. Сонгуулийн тойргийг байгуулахдаа Монгол Улсын Үндсэн Хуулийн хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан суурь зарчимд нийцүүлэн засаг захиргааны нэгж бүрээс төлөөлөл сонгогдох, тойрогт ногдох мандатын тоог тогтоохдоо аймаг, дүүргийн хүн амын тоо, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэрэг шалгуур үзүүлэлтийг харгалзан хуулиар тогтооно.

*Тайлбар:* Энэ зүйлийн Засаг захиргааны нэгж гэдгийг Монгол Улсын Үндсэн Хуулийн тавиндолдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "аймаг, дүүрэг"-ийг ойлгоно.

9/ 20.6.9. Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад суугаа сонгуулийн насны иргэдийн мэдээллийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

20.18. Энэ хуульд заасан журмын дагуу Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эвсэл, төрийн бус байгууллагын төлөөлөл сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, давхардлыг арилгах, нягтлан шалгах, хүргүүлэх үйл ажиллагаатай танилцаж болно.

**10/ 29.9.** Тойрогт болон жагсаалтад зэрэг нэр дэвшихийг хориглоно.

**11/ 30.5.** Нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэн нэр дэвшүүлнэ.

**12/ 48.1.8.** оюутан сурагчдад тэтгэлэг өгөх, эсхүл ирээдүйд өгөхөөр зарлах;

**48.1.9.** төсвийн байгууллагын цалин нэмэх;

**48.1.10.** тэтгэвэр, тэтгэмжийг нэмэх;

**48.1.11.** тухайн жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр эхлүүлэх, хэрэгжүүлэх, зарлах.

**13/ 59.4.** Саналын хуудас нь тойрогт нэр дэвшигч болон нам, эвсэлд санал тэмдэглэх хэсэгтэй байна.

**14/ 65.16.** Санал өгсөн сонгогчид болон сонгогчийн нэрийн жагсаалтын нэгдсэн санд ялгах тэмдэглэгээ хийнэ.

**65.17.** Энэ хуулийн 65.6-д заасан сонгогчийн гарын хурууны хээ болон царайг тулган таниулах ажиллагааг сонгогчийн нэрийн жагсаалтын нэгдсэн сангаас хийх нөхцөл боломжийг Улсын буртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцах бөгөөд Сонгуулийн Ерөнхий хороо, Тагнуулын байгууллага хяналт тавина.

**15/ 71.8.4.** Нам, эвсэл бүрийн авсан саналын тоо.

**16/ 74.1.** Энэ хуулийн 4.3.1 дэх хэсэгт заасан сонгуулийн тойрогт нэр дэвшсэн санал хураалтын дүнг дараах байдлаар гаргана:

**74.1.1.** Сонгуулийн Ерөнхий хороо нь санал хураалтын дүнд үндэслэн тухайн тойрогт нэр дэвшсэн нийт нэр дэвшигчдийг авсан саналын тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргана.

**74.1.2.** Хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.

**74.1.3.** Тойрогт нэр дэвшигчээс хэн нь ч тухайн тойрогт санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал аваагүй бол уг тойргийн дүнг тусад нь гаргана.

**74.1.4** Тойрогт санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчийн тоо тухайн тойргийн мандатын тоонд хүрэхгүй бол үлдсэн мандатад дахин санал хураалт явуулна.

**74.2.** Дараах шаардлагыг хангасан нам, эвсэлд энэ хуульд заасны дагуу суудал хуваарилна:

**74.2.1.** Энэ хуулийн 4.3.1 дэх хэсэгт заасан тойрот ногдох нийт мандатын 50 буюу түүнээс дээш хувьд нэр дэвшилж, суудал авсан байх.

**74.2.2.** Намын тухайд намд өгсөн нийт саналын 3 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх;

**74.2.3.** Хоёр ба түүнээс дээш нам бүхий эвслийн тухайд нам, эвсэлд өгсөн нийт саналын 5 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх;

**74.3.** Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшигчийн санал хураалтын дүнг дараах байдлаар гаргана:

**74.3.1.** Санал хураалтын дүнг үндэслэн нам, эвсэл тус бүрээр авсан саналынх нь тоо, хувиар дараалалд оруулан жагсаалт гаргана.

**74.3.2.** Энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангаагүй нам, эвслийн авсан нийт саналын хувийг мөн хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвсэлд тэнцүү хэмжээгээр хуваан тус бүрийн авсан саналын хувь дээр нэмж тооцно.

**74.3.3.** Энэ хуулийн 74.3.2-т заасны дагуу тооцож гаргасан хувиудын нийлбэрийг 28-д хувааж нэг суудалд ногдох саналын тоо, хувийг тооцож гаргана.

**74.3.4.** Энэ хуулийн 74.3.2-т заасны дагуу тооцож гаргасан нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувийг энэ хуулийн 74.3.3-д заасны дагуу тооцож гаргасан нэг суудалд ногдох саналын хувьд хувааж Улсын Их Хурлын гишүүний 28 суудлыг их үлдэгдлийн зарчмаар хувь тэнцүүлэн хуваарилна.

*Тайлбар: Их үлдэгдлийн зарчмаар хувь тэнцүүлэх хуваарилах гэж энэ хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3.4-т заасны дагуу нэг суудалд ногдох саналын хувьд хуваахдаа бутархай нарийвчлалтай гаргаж, эхний ээлжинд бүхэл хэсэгт нь тэнцэх суудлыг хуваарилах, хэрэв хуваарилагдаагүй суудал үлдвэл хамгийн их үлдэгдэл буюу хамгийн их бутархай хувьтайгаас нь эхлэн нэг нэгээр суудлыг нам, эвсэлд нэмж хуваарилах зарчмаар бүх суудлыг хуваарилж дуусахыг ойлгоно.*

**74.3.5.** Сонгуулийн ерөнхий хороо энэ хуульд заасны дагуу нам, эвслээс ирүүлсэн нэр дэвшигчдийн жагсаалтыг үндэслэн энэ хуулийн 74.3.4-т заасны дагуу хуваарилсан суудлын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.

**77.2.** Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.1-т заасан сонгуулийн тойрот нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний орон гарсан, мөн энэ хуулийн 77

дугаар зүйлийн 77.1-д заасны дагуу сонгогдсонд тооцох дараагийн нэр дэвшигч үлдээгүй бол нөхөн сонгууль явагдана.

**2 дугаар зүйл: Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:**

**1/ 4 дугээр зүйлийн 4.3 дахь хэсэг:**

"4.3. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 76 гишүүнийг дараах байдлаар сонгоно:"

**2/ 7 дугаар зүйлийн 7.1 дахь хэсэг:**

7.1. Сонгуулийн зарчим нь Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах, санал гээгдэхгүй байх зарчимд үндэслэнэ.

**3/ 9 дугээр зүйлийн 9.2 дахь хэсэг:**

9.2. Ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын сүүлийн хагасын аль нэг ажлын өдөр байх бөгөөд гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдөр /цаашид "гадаадад санал авах өдөр" гэх/-ийг сонгуулийн төв байгууллага /цаашид "Сонгуулийн өрөнхий хороо" гэх/-ын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

**4/ 14 дугаар зүйлийн 14.12 дахь хэсэг:**

14.12. Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн нь Улсын Их Хурлаас баталсан сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрэмд захирагдах бөгөөд Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хуралд суудалтай нам, эвслээс солбиж томилно.

**5/ 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг:**

"30.1. Нам, эвсэл нь энэ хуулийн 4.3.1 дэх хэсэг заасан сонгуулийн тойрот нэр дэвшигч нэр дэвшүүлэхгүй байх эсхүл хэдэн ч тойрот нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд нийт 48-аас илүүгүй хүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойрот, 28-аас илүүгүй хүнийг жагсаалтаар тус тус нэр дэвшүүлнэ"

**6/ 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг:**

30.2. Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 40-оос доoshгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.

**7/ 51 дүгээр зүйлийн 51.3:**

51.3. Сонгуульд оролцох сонирхол бүхий нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс сонгуулийн хандивын дансыг нээлгэж болно.

**8/ 65.6. Санал авах байранд ажиллаж буй итгэмжлэгдсэн ажилтан санал өгөхөөр ирсэн сонгогчийн гарын хурууны хээ болон царайг нэгдсэн сан дахь сонгогчийн нэрсийн жагсаалттай тулган таниулж, энэ хуулийн 66.5-д заасан бэхэн**

тэмдэглэгээ хийгдсэн эсэхийг нягтлан шалгасны үндсэн дээр зөрчилгүй бол сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.

**9/ 66.5.Сонгогч саналаа тэмдэглэсэн саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийсний дараа санал өгснийг батлах бэхэн тэмдэглэгээг баруун гарын долоовор хуруунд хийлгэж санал авах байраас гарна. Сонгогчийн сонгуульд оролцсоныг батлах бэхэн тэмдэглэгээг дахин болон нэмэлт саналт хураалт явагдах үед баруун гарын долоовор хуруунаас өөр аль нэг хуруунд хийнэ.**

**3 дугаар зүйл:** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "иргэн" гэсний дараа "гадаад улсад суугаа Монгол Улсын иргэн" гэснийг, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь хэсэгт "программ хангамж" гэсний дараа "сонгогч санал өгсөнийг тэмдэглэх бэх түүний дагалдах хэрэглэл" гэснийг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн "шийдвэрлэх ажлыг" гэсний дараа "Сонгуулийн ерөнхий хорооны хяналт дор" гэснийг, "зохион байгуулж," гэсний дараа "энэ хуульд заасан журмын хүрээнд" гэснийг, 20.5 дахь хэсгийн "холбогдох мэдээлэлтэй" гэсний дараа "болон байнга оршин суугаа хаягт бүртгэлтэй бусад сонгогчдын мэдээлэлтэй" гэснийг, 20.13 дахь хэсгийн "цахим хэлбэрээр" гэсний өмнө "санал авах өдрөөс 5 хоногийн өмнө 2 удаа" гэснийг, 20.14 дэх хэсгийн "хэлбэртэй" гэсний араас "нэгдсэн нэг сантай" гэснийг, 20.16 дахь хэсгийн "байгууллага" гэсний дараа "Сонгуулийн Ерөнхий хороотой хамтран" гэснийг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн "жагсаалт дахь" гэсний дараа "энэ хуулийн 20.5 дахь хэсэгт заасан" гэснийг, "буруу бүртгэгдсэн," гэсний дараа "байнга оршин суугаа газрын хаягт нь бүртгэлгүй сонгогч нэмэгдсэн зэрэг асуудлаар" гэснийг, "бичгээр" гэсний дараа "болон цахимаар" гэснийг, " 67 дугаар зүйлийн 67.14 дэх хэсэгт "67.13" гэсний өмнө "67.1" гэснийг ... гэснийг тус тус нэмсүгэй.

**4 дүгээр зүйл:** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.11 дэх хэсгийн "14-өөс доошгүй" гэснийг "5-аас доошгүй" гэж, 20.13 дахь хэсгийн "санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө" гэснийг "нам, эвсэл бүртгүүлснээс хойш ажлын 3 хоногт" гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн "14-өөс доошгүй" гэснийг "5-аас доошгүй" гэж, .... гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл:** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн... гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл:** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг,11 дүгээр зүйлийн 11.2, 12 дугаар зүйлийн 12.4, 14.12 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.15 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 50 дугаар зүйл, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6, ... дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл:** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн дугаарыг 12.4 гэж, 20 дугаар зүйлийн 20.16 дахь хэсгийн дугаарыг 20.15, 20.17 дахь хэсгийн дугаарыг 20.16 гэж, гэж тус тус өөрчилсүгэй.

### Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд дараах агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:**

28.8.“Дэд хорооны даргыг харьялах Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхын саналаар сонгох бөгөөд Төсвийн зарлагын дэд хороо” гэсний араас “Сонгогчдын нэrsийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс, хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгоно” гэж нэмэх

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ....ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

**1/1.14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэг:**

“сонгуульд нэгээс илүү санал өгсөн” гэсний дараа “санал өгөхийг завдсан” гэж;

**2/1.14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг:**

“...авахыг зохион байгуулсан” гэсний дараа “сонгуульд ашиглах иргэний улсын бүртгэлийн мэдээлэл болон сонгогчийн нэрийн жагсаалтад хуурамч мэдээлэл оруулсан, сонгогчийн нэрийг нэгээс илүү хаягт давхардуулан бүртгэж сонгуульд илүү санал өгөх нөхцөлөөр хангасан” гэж тус тус нэмсүгэй.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ... дугаар  
сарын ....ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төсвийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг нэмсүгэй:

6.4.9.Бүх шатны сонгуулийн өмнөх жилийн төсвийг батлахдаа оюутан, сурагчдад тэтгэлэг, тусламж өгөх, цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэх, нийгмийн халамж хамгааллын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхийг хориглох.

Гарын үсэг

**УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН СУДАЛГАА**

**Улаанбаатар хот 2022 он**

**УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН СУДАЛГАА**

**НЭГ. Ерөнхий мэдээлэл**

**ХОЁР. Асуудлын дүн шинжилгээ**

**ГУРАВ. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн харьцуулалт**

**ДӨРӨВ. Асуудлыг зохицуулах хувилбарууд, эерэг болон сөрөг тал дээр хийсэн харьцуулалт**

**ТАВ. Сонгосон хувилбарын үр нөлөөг тандан судалсан байдал**

**ЗУРГАА. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт**

**ДОЛОО. Олон улсын болон бусад улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал**

**НАЙМ. Зөвлөмж**

# **УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНДАН СУДАЛГАА**

## **НЭГ. Еренхий мэдээлэл**

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд хэлэлцэн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьж байна. Сонгуулийн тогтолцоонд пропорциональ элементийг оруулах, улмаар гадаад буй иргэдийн саналыг авах, хүсийн харьцааг нарийвчлан заах, жагсаалтын саналыг нам бус иргэдээр эрэмбэлүүлэх гэх мэт олон жилийн турш яригдсан, нийгмийн эрэлттэй агуулгуудыг тусган уг хуулийн төслийг өргөн барьж байна.

## **ХОЁР. Асуудалд дүн шинжилгээ хийх**

### **Асуудлын хамрах хурээ**

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх тандалт судалгаа шинжилгээг хийсэн.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахтай холбогдуулан иргэдээс гаргасан санал, тухайн салбарын судлаачдын хүсэлт зэргийг судалж энэхүү судалгааг хийсэн болно.

#### **Эрх зүйн зохицуулалтын талаар:**

- Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд:
- Монгол Улсын нийт иргэн, хуулийн этгээдүүдийн эрх ашиг хөндөгдөж байна.
- Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

Улсын Их Хурлын сонгуулиудын түүхэн үр дүнг судлан, сургамж, алдааг анхааран, тэдгээрийг нарийвчлан зохицуулж, одоого үүсээд буй зохицуулалтгүй хийдэлтэй асуудлыг хуульчлах шаардлагатай. Энэ хүрээнд иргэдийн сонгох, сонгогдох эрх хийгээд гээгдэж буй саналыг аль болох бага байлгахад анхаарч, сонгуульяй холбоотой түгээмэл зерчлүүдийг залруулахад чиглэн хариуцлагын механизмыг хуульчлах шаардлагатай болсон.

## **ГУРАВ. Асуудлыг шийдвэрлэх зорилго**

### **2.1. Гол зорилго, зорилт**

Энэхүү үнэлгээний тайлангийн нэгд заасан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага урган гарч байгаатай холбогдуулан Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх еренхий зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Улсын Их хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар иргэдийн сонгох, сонгогдох эрх хангагдаж, санал гээгдэх, гадаадад буй иргэдийн санаалаа өгөх боломж бүрдэнэ.

## **ДӨРӨВ. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн харьцуулалт**

### **3.1. Асуудлыг зохицуулах хувилбарууд**

Энэхүү үнэлгээний тайлангийн Нэгд заасан асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу "зорилгод хүрэх байдал" буюу Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах замаар нийгэм дээрх бэрхшээлийг арилгах зорилгоор шийдлийг сонгох хувилбарыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь заалт, Хууль

тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалд тус тус заасны дагуу Хуулийн төсөл боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Асуудалд дүн шинжилгээ хийх явцад хуулийг батлахгүйгээр асуудлыг шийдвэрлэх гарцуудын талаар тодорхой судалгаанууд хийгдсэн.

- “Тэг” хувилбар буюу хуулийн төсөл боловсруулахаас татгалзах. Энэ тохиолдолд өнөөгийн мөрдөж буй эрх зүйн зохицуулалтын хүрээнд зохицуулалт байх боловч одоо үүсч буй хэрэгцээ шаардлагыг хангах боломжгүй байна. Улмаар төсөв, төсвийн хүрээний мэдэгдлийг ямар уялдаа бодлогогүйгээр төлөвлөх, түүний төлөө хүлээх хариуцлагын механизм байхгүй байна. Хуулийн төслийг боловсруулахгүй байх нь үүсч буй хүндрэлийг шийдвэрлэх боломжгүйд хүрэхээр байна.

- Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх. Уг асуудал нь хуулиар шууд зохицуулагдах харилцаа учир хуулийн төсөл боловсруулах шаардлагатай.

- Зах зээлийн механизмаар төрөөс зохицуулалт хийх. Төрөөс санхүүгийн интервенц хийх. Төрөөс санхүүгийн интервенц хийх буюу шууд мөнгөн хэлбэрийн дэмжлэг үзүүлэх аргаар зохицуулах боломжгүй юм. Энэ нь зарчим буюу бодлого төлөвлөх, хэрэгжилтийг хангах процессын зохицуулалт болно.

- Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх. Төсөв боловсруулах асуудал нь Үндсэн хуулийн дагуу Засгийн газрын бүрэн бэрх, батлах асуудал нь УИХ-ын бүрэн эрх тул бусад этгээдээр гүйцэтгүүлэх боломжгүй харилцаа юм.

- Захиргааны шийдвэр гаргах. Үндсэн хуульд зааснаар төсөв, төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн тусгай үаардлагыг хуулиар тогтоож өгсөн бөгөөд уг харилцааг хуулиар зохицуулах зайлшгүй шаардлагатай учир захиргааны шийдвэр гаргах арга замаар шийдвэрлэх боломжгүй юм.

- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах. Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу хуулийн төсөл батлах замаар шийдвэрлэх боломжтой юм.

### 3.2. Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулсан тухай

Зорилгод хүрэх байдал: Зорилгод хүрэх байдлыг өмнө хийгдсэн судалгаа, санал асуулга, ашиг сонирхол нь хөндөгдэж байгаа этгээдүүд болон салбарын мэргэжилтнүүдийн санал зэргийг үндэслэн тодорхойллоо.

Тэг хувилбарыг сонгосноор тухайн асуудал шийдвэрлэгдэхгүй орхигдох сөрөг талтай.

Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх хувилбарыг сонгосноор тухайн харилцааг зохицуулах боломжгүй тул уг хувилбарыг сонгох боломжгүй байна.

Зах зээлийн механизмаар төрөөс зохицуулалт хийх. Төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбарыг сонгосноор төрөөс санхүүгийн интервенц хийх буюу шууд мөнгөн хэлбэрийн дэмжлэг үзүүлэх аргаар зохицуулах боломжгүй юм.

Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх хувилбарыг сонгосноор боломжгүй бөгөөд хуульд заасны дагуу төрийн байгууллага өөрөө хариуцан гүйцэтгэх шаардлагатай.

Захиргааны шийдвэр гаргах хувилбар сонгосноор бүрэн хэрэгжилтийг хангах боломжгүй юм.

Зардал, үр өгөөжийн харьцаа: Хуулийн төсөл баталснаар нэмэлт зардал гарахгүй тул зардлын тооцоо хийх шаардлагагүй.

### 3.3. Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай

Энэхүү тандан судалгааг хийх явцад зохицуулалтын нэг л хувилбар буюу хууль тогтоомжийн төслийг боловсруулах хувилбарыг сонгон авсан болно. Хууль тогтоомжийн тухай хуулийн 5.1-т заасны дагуу хуулийн тесэл боловсруулан хуулийн тесэл батлах замаар шийдвэрлэх боломжтой гэж үзсэн.

**ТАВ. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөний талаар**

Сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн хууль тус бүрээр гаргалаа.

**ХҮНИЙ ЭРХ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ  
ҮР НӨЛӨӨНИЙ ТАНДАЛТЫН СУДАЛГАА  
ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**

| Үзүүлэх үр нөлөө                                      | Холбогдох асуулт   | Хариулт | Тайлбар                                  |
|---|--|---------|--|
| 1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх    | <p>1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх</p> <p>1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх</p> <p>1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх</p> <p>1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нехцел байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх</p> <p>1.2.Оролцоог хангах</p> <p>1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгоходоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бурдуулсан эсэх</p> <p>1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх</p> <p>1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</p> <p>1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх</p> <p>1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх</p> <p>1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх</p> | Үгүй    | Ямар нэгэн серег нөлөө байхгүй           |
| 2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх | <p>2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх</p> <p>2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх</p>   | Үгүй    | Ямар нэгэн серег нөлөө байхгүй           |
| 3.Эрх агуулагч  | <p>3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх</p> <p>3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх</p> <p>3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нехцел байдлыг харгалзан</p>   | Үгүй    | Ямар нэгэн серег нөлөө байхгүй.          |
|   |  | Үгүй    | Ямар нэгэн байдлаар ялгаж тодорхойлоогүй |
|   |  | Үгүй    | Ямар нэгэн серег нөлөө байхгүй           |

|   |  |      |   |
|---|--|------|---|
|   | үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх  |      |   |
|   | 3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй) | Үгүй | Ямар нэгэн сөрөг нелөө байхгүй                |
| 4.Үүрэг хүлээгч   | 4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх  | Тийм | Төр үүрэг хүлээнэ                             |
| 5.Жендерийнэрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх | 5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх   | Үгүй | Уг тогтоолд жендерийн эрх хөндөгдөхгүй болно. |
|   | 5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх  | Үгүй | Уг тогтоолд жендерийн эрх хөндөгдөхгүй болно. |

## ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө   | Холбогдох асуулт   | Хариулт | Тайлбар                        |
|--|--|---------|--------------------------------|
| 1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар                              | 1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх<br>1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдхөхийг оролцуулан)<br>1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх                     | Үгүй    | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
|  | 2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх  | Үгүй    | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон засэх тогтвортой байдал | 2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх<br>2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх<br>2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх  | Үгүй    | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
